

Хануул дүүргийн Нэгдсэн эмнэлэг нь

Анх БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах яам, Улаанбаатар хотын АДХГЗ-ны 1979 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 347/287 тоот тогтоолоор Хүүхдийн 120 ортой больниц амбулаторийн баримтыг хүлээн авах тогтоол гарч, 1980 оны 4 сард Ажилч ний районы Хүүхдийн нэгдсэн эмнэлэг нэртэйгээр анх байгуулагдсан. хэвтэн эмчлүүлэх 12 ортой, нэг ээлжиндээ 300 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай поликлиниктэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

1991 оны 4-сард ЭМ Сайдын А/39, Улаанбаатар хотын АДХГЗ-ны 83-р тогтоолоор нийслэлийн дүүргүүдэд эрүүл мэндийн зөвлөх төвүүд байгуулагдаж, амбулатори поликлиникин үйлчилгээг шилжүүлснээр хүүхдийн өвчний чиглэлээр хэвтүүлэн эмчлэх үйлчилгээтэй хүүхдийн 4-р эмнэлэг болж өөрчлөгдсөн.

Тус эмнэлгийн Эрүүл мэндийн сайд, нийслэлийн Засаг дарга 2001 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 98/197 тоот хамтарсан тушаал, захирамжаар дүүргийн нэгдсэн эмнэлэг болгон өөрчлөн зохион байгуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээ, нэр төрлийг нэмэгдүүлсэн,

Нэгдсэн эмнэлэг нь 1993 оноос дотрын тасаг, 2002 оноос мэс заслын тасаг, 2005 оноос уламжлалт эмчилгээний тасаг 2008 оноос "Сэтгэлийн илч" клиник сувиллыг тус тус шинээр нээгдэж үйл ажиллагаа явуулжээ.

Бүтэц нь: 90 гаруй эмч ажилтантай бөгөөд 22 их эмч, 35 сувилагч тусгай мэргэжилтэн, 15 асрагч, 6 инженер техникийн ажилтан ажиллаж байна.

Алсын хараа Эмчилгээ оношлог-ооны ажилд орчин үеийн тоног төхөөрөмжийг өргөнөөр ашиглаж, өндөр нарийн мэргэжлийн боловсон хүчний нөөцийг бий болгон хэрэглэгчдэд, тэдний хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан баталгаатай, чанар тусламж үзүүлэхэд оршино. Хамт олон 2001 оноос Эрүүл ээлтэй орчин-ээлдэг чанартай үйлчилгээ уриан дор зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж ажилласан.

Удирдлага зохион байгуулалт: удирдлагын хосолсон бүтэцтэй үндсэн үйл ажиллагааны төрөлжсөн 6 тасагтай, мэргэжил арга зүйн 4 албатайгаар зохион байгуулагдан ажилласаар ирсэн.

Эмнэлгийн үйл ажиллагааны онцлог нь:

Үйлчлэх хүрээний хүн амд дотор, мэдрэл, мэс засал, хүүхэд, уламжлалт эмчилгээ, оношлог ооны чиглэлээр хоёрдогч шатлалтын тусламж үйлчилгээг үзүүлж байна. Тус эмнэлэг нь 115 ортой жилдээ дунджаар 5000 гаруй хүн хэвтэн эмчлүүлдэг, нэгдсэн лаборатори, үйл оно шийн кабинет, дүрслэл оношлог ооны кабинет, нөхөн сэргээх-физик эмчилгээний кабинет, эрүүл мэнд сургалт сурталчилгааны кабинетууд ажиллаж эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

2001 оноос эмнэлгийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр эмнэлгийн үйлчилгээг хэвийн явуулах нийгэм хамт олны болон эдийн засгийн ээлтэй орчинг бүрдүүлсэн.

2003-2004 онд "Дүүргийн нэгдсэн эмнэлэг-өөрчлөлт-шинэчлэл" төслийн хүрээнд оношлог-ооны болон эмчилгээний зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.

Тус эмнэлгийн удирдлагын баг 2006 оноос эхлэн Хануул эмнэлгийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан батлуулсан. 2002 оноос нөхөн сэргээх кабинетуудыг 2005 оноос хөдөлгөөн эмчилгээний кабинетуудыг шинээр нээсэн.